



МОНГОЛ УЛСЫН
СОЁЛЫН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

“Аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газрын”
зохион байгуулалтын бүтэц,
дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай” 360 дугаар тогтоолын 5.17, “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоолын 4.13 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Соёл, урлагийн газрын зохион байгуулалтын бүтцийг нэгдүгээр, дүрмийг хоёрдугаар, аймгийн Соёл, урлагийн газрын зохион байгуулалтын бүтцийг гуравдугаар, дүрмийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийг 2022 оны I улиралд багтаан танилцуулахыг Төрийн нарийн бичгийн дарга (С.Оюунбилэг)-д даалгасугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Соёлын сайдын 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн “Соёлын хэлтсийн үлгэрчилсэн дүрэм батлах тухай” А/158 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ч.НОМИН



НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



1. Соёл, соёлын өвийн хэлтсийн чиглэл нь Бүх нийтийн соёлын бэлтгэл, соёл гэгээрүүлэх үйл ажиллагаа болон соёлын өвийн асуудлын хэрэгжлтийг хариуцна.
2. Соёлын үйлдвэрлэл, урлагийн салбарын үйл ажиллагааны чиглэл нь урлагийн үйлдвэрлэл болон соёлын Бугаагч үйлдвэрлэлийн бүх салбар, чиглэлийг хамруулсан төлөвлөлийн хэрэгжлтийг хариуцна.
2. Үйл ажиллагааны үндсэн хэрэгжлэл, хэрэгжлэл талууд нь Тар-ТББ-Хувийн хэвэл, цэргэд байна.

Танх гэмдэг. Шууд хамраар. Чиг үүрэг.